# СТАНДАРТ ХЭМЖИЛЗҮЙН ХЭЛТСИЙН ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛ

## ТОГТООЛ №6

2020 оны 05 сарын 05 Мандалговь хот

Тохирлын үнэлгээний тухай

Стандартчилал техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13 зүйлийн 2 " Бүтээгдэхүүний баталгаажуулалтын байгууллагад тавих ерөнхий шаардлага" MNS ISO/IEC 17065:2013 стандартын 7.6 заалт, орон нутгийн орон тооны бус баталгаажуулалтын зөвлөлийн дүрмийн 1 зүйлийн 1.4.1 заалтыг тус тус үндэслэн баталгаажуулалтын байгууллагын орон тооны бус зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Дээрх заалтуудыг үндэслэн 2020 оны 05 сарын 05-ны орон тооны бус зөвлөлийн хурлын шийдвэрээр стандартын шаардлага хангасан аж ахуй нэгж, иргэнд тохирлын гэрчилгээ олгох эрхийг зөвлөлийн нарийн бичгийн дарга Б.Бямба-Оюунд зөвшөөрч, /хавсралт-1/ баталсугай.
2. Баталгаажуулалтын орон тооны бус зөвлөлийн шийдвэрээр Гурвансайхан сумын Буман цагаан хоньт ХХК, Уул хадарганатай ХХК, Цэнхэр говь ХХК, Донид пагма ХХК, иргэн У.Хүдэрчулууны худалдааны газар, Өндөршил сумын Тасын хашаат ХХК, Чебу ХХК, Баянжаргалан сумын иргэн Ц.Бадамхандын мухлаг, Цагаандэлгэр сумын иргэн Ж.Отгонсуурийн мухлаг, Говь-Угтаал сумын Дэлгэрхонгор ХХК, Өлзийт сумын иргэн С.Баяраа, А.Ганцогт нарын худалдааны газруудад 2 жилийн хугацаатай тохирлын гэрчилгээг олгосугай.
3. Давтан баталгаажуулалт хийж, тохирлын үнэлгээний түвшинд хүрээгүй аж ахуй нэгж байгууллагад мэдэгдэл өгч холбогдох арга хэмжээ авч ажиллахыг орон тооны бус зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Бямба-Оюун/ -д үүрэг болгосугай.

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА А.ПҮРЭВСҮРЭН

ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БЯМБА-ОЮУН

Баталгаажуулалтын байгууллагын
орон тооны бус зөвлөлийн 2020 оны
05 сарын 05-ны өдрийн 6-р тогтоолын
1 дүгээр хавсралт

***Тохирлын гэрчилгээ шинээр олгосон, сунгуулсан ААН, иргэдийн нэрс***

| № | Сумын нэр | Аж ахуй нэгж | Үйлчилгээний нэр |
|---|---|---|---|
| 1 | Гурвансайхан | Буман цагаан хонь ХХК | Худалдаа |
| 2 | Гурвансайхан | Уул хадарганатай ХХК | Худалдаа |
| 3 | Гурвансайхан | Цэнхэр говь ХХК | Худалдаа |
| 4 | Гурвансайхан | Донид пагма ХХК | Худалдаа |
| 5 | Гурвансайхан | Иргэн У.Худэрчулуун | Худалдаа |
| 6 | Өндөршил | Тасын хашаат ХХК | Худалдаа |
| 7 | Өндөршил | Чебу ХХК | Худалдаа |
| 8 | Баянжаргалан | Иргэн Ц.Бадамханд | Мухлаг |
| 9 | Баянжаргалан | Иргэн Ц.Бадамханд | Худалдаа |
| 10 | Цагаандэлгэр | Иргэн Ж.Отгонсуурь | Мухлаг |
| 11 | Говь-Угтаал | Дэлгэрхонгор ХХК | Худалдаа |
| 12 | Өлзийт | Иргэн С.Баяраа | Худалдаа |
| 13 | Өлзийт | Иргэн А.Ганцогт | Худалдаа |

Жагсаалт гаргасан: ДУНДГОВЬ АЙМГИЙН ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛ Б.Бямба-Оюун